



БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НАРАНТУЯА

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2017 оны 7 сарын 01-ны өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

2017 07 05 086

Энэхүү ажил гүйцэтгэх гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г

Нэг талаас: Эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид "Захиалагч" гэх/, түүнийг төлөөлж, Статистик, мэдээллийн технологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Ганцэцэг,

Нөгөө талаас: Иргэн Батбаяр овогтой Буянжаргал нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээ нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр Эрүүл мэндийн статистикийн "Эйч Инфо" програм хангамжийг боловсруулах болон бусад холбогдох ажил үйлчилгээ, хөгжүүлэх, турших, нэвтрүүлэх ажлыг хийж гүйцэтгэхтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах, тэдгээрийн эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ГЭРЭЭ ЦУЦЛАХ

- 2.1. Ажил гүйцэтгэгч нь энэхүү гэрээний 1.1-д заасан ажлыг 2017 оны 7-р сарын 01-ны өдрөөс 2017 оны 12-р сарын 30-ний өдөр хүртэл хугацаанд хийж гүйцэтгэсэн байна.
- 2.2. Гүйцэтгэгч тал гэрээний хүчинтэй хугацаанд ажлыг гүйцэтгэхдээ өдрийн 8 цаг, долоо хоногийн 40 цаг ажиллана.
- 2.3. Дараах тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.
 - a. Талууд харилцан тохиролцсоноор,
 - b. Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд нөгөө талын санаачлагаар

ГУРАВ. АЖЛЫН ХӨЛС

- 3.1. Гэрээт ажлын хөлсийг нэг сарын 1480000₮ /нэг сая дөрвөн зуун наян мянган төгрөг/-өөр тогтоов.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 4.1. Захиалагч нь гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлын гүйцэтгэлийг 2017 оны 12-р сарын 30-ны дотор хүлээн авч, дүгнэнэ.

- 4.2. Гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л асуудлаар мэдээ, мэдээлэл авах, санал, хүсэлт, гомдол гаргах, ажлын чанарт шаардлага тавьж ажиллана.
- 4.3. Ажлын явц, гүйцэтгэлийг хянаж, ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэхийг шаардах.
- 4.4. Гүйцэтгэгч талаас ажлын явцын тайланг 14 хоног тутамд гаргуулж авах.
- 4.5. Гүйцэтгэгч талд гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах компьютер, тоног төхөөрөмж, бичиг баримт болон холбогдох бусад мэдээллээр хангах.
- 4.6. Гүйцэтгэгч талын буруутай үйл ажиллагааны улмаас байгууллагад хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлүүлэх, гүйцэтгэж буй ажлын чанар, доголдлыг арилгуулахаар шаардлага тавих.

ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 5.1. "ГЭТҮ" буюу Гэрийн эргэлтийн тусламж үйлчилгээний системийг хөгжүүлэх ажлыг төлөвлөгөөт хугацаанд мэргэжлийн өндөр түвшинд чанартай гүйцэтгэж Захиалагчид хүлээлгэн өгөх гол үүрэгтэй.
- 5.2. Шаардлагатай тохиолдолд Захиалагч талаас ажлын гүйцэтгэлтэй холбогдуулан тусламж авах, холбогдох албаны мэргэжилтэн, програмистуудыг ажлын гүйцэтгэлд оролцуулах.
- 5.3. Гэрээний дагуу гүйцэтгэх ажилд шаардагдах материал, техник хэрэгслийг Захиалагч талаас гаргуулан авах.
- 5.4. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг Захиалагч талд нөхөн төлнө.
- 5.5. Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээ, мэдээллийг бусдад ямар нэгэн байдлаар задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.
- 5.6. Гэрээний хүчинтэй хугацаанд энэхүү гэрээгээр хэрэгжүүлж буй ажил болон ижил төстэй ажлыг өөр бусад байгууллагад хэрэгжүүлэх, зохион байгуулахыг хатуу хориглоно.
- 5.7. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлж болохгүй

ЗУРГАА. ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

- 6.1. Гэрээний үүрэг хэрэгжих явцад Талуудын хамтын ажиллагааны ёс зүйг эрхэмлэн байгууллагын нэр хүнд болон түүнд хамаарах бусад үнэт зүйлсийг хүндэтгэж ажиллана.
- 6.2. Талууд хамтын ажиллагааны явцад олж авсан нууцад хамаарах аливаа мэдээллийг шууд буюу шууд бусаар хортойгоор буруугаар ашиглах болон гуравдагч этгээдэд задруулахыг хатуу хориглоно.
- 6.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ хэсэгчлэн болон бүтнээр нь биелүүлээгүй, санаатай болон санамсаргүй үйлдсэн буруутай үйл ажиллагаанаас нөгөө талдаа учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 7.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас захиалагч буюу гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих хугацаанд хийж гүйцэтгэх боломжгүй болбол нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэж, шаардлагатай хугацаагаар түүнийг гүйцэтгэх хугацааг сунгана.

НАЙМ. БАТАЛГАА

- 8.1. Гэрээний дагуу талуудаас гаргаж өгсөн болон гаргаж өгөх бүх баримт бичиг, мэдээлэл, баталгаа нь үнэн зөв бөгөөд гэрээ хүчин төгөлдөр болоход зайлшгүй шаардлагатай аливаа чухал нөхцөл байдлыг орхигдуулаагүй.

ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 9.1. Гэрээтэй холбогдон үүсэх аливаа маргаантай асуудлыг талууд эв зүйгээр зохицуулахыг эрмэлзэх бөгөөд ингэх боломжгүй нөхцөл байдал үүсвэл МУ-ын шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

АРАВ. БУСАД ЗҮЙЛ

- 10.1. Гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 10.2. Гэрээ нь адил хүчинтэй хоёр хувь үйлдэгдсэн бөгөөд Талууд тус бүрт нэг нэг хувь хадгалагдана. Талууд гэрээг хувилж тараахыг хориглоно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
СТАТИСТИК, МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН АЛБАНЫ ДАРГА

Х. Ганцэцэг

Х. ГАНЦЭЦЭГ 86331

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Б. БУЯНЖАРГАЛ

Б. Буянжаргал